

Батлав
ЭМЯ-ны дэргэдэх Эрчимт эмчилгээний
судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн
ерөнхий мэргэжилтэн  Б.Цолмон

2026 оны 02 сарын 02-ны өдөр

ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭ СУДЛАЛ МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРЛАГА

Энэхүү тусгай шаардлагыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл зөвшөөрсөн өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай мөрдөнө.

Монголын эрчимт эмчилгээний нийгэмлэгийн удирдах зөвлөлийн хурлаар гишүүдийн саналыг тусгаж, ЭМЯ-ны дэргэдэх Эрчимт эмчилгээ судлалын мэргэжлийн салбар зөвлөлөөр баталгаажуулав.

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Журмын дагуу нийтлэг шаардлагыг хангасан байна.
2. Мэргэжлийн болон АУ-ны бусад сэтгүүлд 2-оос доошгүй илтгэл эсвэл өгүүлэл нийтлүүлсэн байх. Дээрх илтгэл, өгүүллийн хуулбарыг сэтгүүл, номын нүүрийн хамт хувилж хавсаргана.
3. Мэргэжлийн нийгэмлэгийн үйл ажиллагаанд тасралтгүй, идэвхтэй оролцдог байх.
4. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 8 жилийн ажлын тайлан гаргах.
5. Ажиллах хугацааны сүүлийн 3-аас доошгүй жилд өөрийн эмнэлэг дээр залуу эмч, резидент эмч нарыг дагалдуулж сургасан байх (8 жилийн ажлын тайланд оруулах).

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Журмын дагуу нийтлэг шаардлагыг хангасан байна.
2. Мэргэжлийн болон АУ-ны бусад сэтгүүлд 4-өөс доошгүй илтгэл эсвэл өгүүлэл нийтлүүлсэн байх. Дээрх илтгэл, өгүүллийн хуулбарыг сэтгүүл, номын нүүрийн хамт хувилж хавсаргана.
3. Мэргэжлийн нийгэмлэгээс зохиосон ажилд идэвхтэй оролцсон байх.
4. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилийн ажлын тайлан.
5. Сүүлийн 5 жилд залуу эмч, резидент эмч нарыг дагалдуулж сургасан байх (5 жилийн ажлын тайланд оруулах).
6. Нийгэмлэгийн сургалт, семинарт онол, эрдэм шинжилгээний чиглэлээр 5-аас доошгүй удаа илтгэл, лекц уншсан байх (5 жилийн ажлын тайланд оруулах).

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Журмын дагуу нийтлэг шаардлагыг хангасан байна.
2. Бүтээлийн жагсаалт гаргах, нийтдээ 5-с доошгүй өгүүлэл, 20-с доошгүй илтгэл нийтлүүлсэн байх.

3. АУ-ны бакалавраас дээш боловсролын зэрэгтэй (магистр, эсвэл доктор) байх.
4. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайлан.
5. Үндэсний хэмжээний эмнэлзүйн удирдамж (2-оос доошгүй) боловсруулсан, эсвэл боловсруулахад оролцсон байх.



Боловсруулсан:Т.Эрдэнэчимэг /МЭЭН-ийн тэргүүн/